



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар

1/20

Мандалговь

**3.Нямыг Цагаандэлгэр сумын Засаг даргын
Тамгын газрын Төсөв, төрийн сангийн мэргэжилтний
албан тушаалд нэр дэвшүүлэх тухай**


Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2023 оны 01 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын Төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Зоригт овогтой Ням 62.4 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа 3.Нямын холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг Салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ





**Цагаандэлгэр сумын ЗДТГ-ын төсөв, төрийн сангийн мэргэжилтний
албан тушаалд нэр дэвшүүлсэн З.Нямын тухай дүгнэлт**

1. З.Ням нь 1985 онд Дундговь аймгийн Хулд суманд төрсөн. 38 настай, эмэгтэй
2. Боловсрол: 2003-2007 онд Өлзийт дээд сургуулийг нягтлан бодогч эдийн засагч мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн.
3. 2010-2015 онд Улсын бүртгэлийн хэлтсийн Цагаандэлгэр сумын улсын бүртгэгч, 2022 онд Цагаандэлгэр сумын хөдөлмөр халамжийн асуудал хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байсан.
4. З.Нямын төрийн албаны дадлага туршлага, тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Цагаандэлгэр сумын ЗДТГ-ын төсөв, төрийн сангийн мэргэжилтний албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ